

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

#### **1.1. Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2-т “Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална.” гэж тусгасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэж заасан бөгөөд энэ зорилгын хүрээнд нийцүүлэн тодорхойлсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг төрийн бодлогоор онцгойлон дэмжихээр тусгасан. Уг зорилгыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна”, “Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна”, “Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зохицуулалтын орчныг сайжруулна” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.2.3-т “гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ” гэж заасан.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3.5-т “Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн оролцогчдын хүрээг тэлэх бодлого хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах татварын таатай орчныг бүрдүүлнэ” гэж, 3.2.2.2-т “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 4.4.2.15-т “Монгол Улсын хөгжлийн бодит хэрэгцээ, шаардлагыг хангахуйц эдийн засаг, нийгмийн ач

холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн гадаад харилцаа, гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлд төрийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, үр өгөөжийг дээшлүүлнэ.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилгод “Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна”, “Бүс, орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлнэ”, “Татвар, санхүүгийн ялгаатай бодлогыг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд заасны дагуу Монгол Улс нь өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгийг бий болгохын тулд хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зохицуулалтын орчныг сайжруулах хууль зүйн шаардлага бий болж байна.

## **1.2.Практик шаардлага**

НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD)-ын судалгаагаар дэлхий даяар гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) 2023 онд 1.3 их наяд долларт хүрч, жилийн дотор 10 хувиар буурчээ.

Дэлхийн хөрөнгө оруулалтын орчин 2024 онд сорилт дагуулсан хэвээр байна. Эдийн засгийн өсөлт саарч, геополитикийн байдал хурцдан, том улсуудын аж үйлдвэрийн бодлого өөрчлөгдөж, нийлүүлэлтийн сүлжээний төрөлжилт явагдаж байгаа зэрэг нь ГШХО-ын хэв маягийг өөрчилж байгаа хэдий ч үндэстэн дамнасан компаниудын ашиг, орлого нэмэгдэж, санхүүжилтийн нөхцөл хөнгөрч, шинэ төслийн тоо нэмэгдэж байгаа нь ГШХО-д эерэгээр нөлөөлж байна.

Хөгжиж буй орнуудад оруулсан ГШХО 2023 онд 7 хувиар буурч, 867 тэрбум ам.долларт хүрсэн ч, бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна. 1000 гаруй шинэ төслүүд нэмэгдсэний хагас нь Зүүн Өмнөд Азид, дөрөвний нэг нь Баруун Азид ногдож байна. Дэлхий даяар хөрөнгө оруулалт дэд бүтэц, дижитал эдийн засгийн салбарт багассан ч, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, чухал ашигт малтмалын салбаруудад өсжээ.

Хөгжиж буй орнууд ихэвчлэн хөрөнгө оруулалтыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой байдаг бол хөгжингүй орнууд илүү хязгаарлах арга хэмжээ авахыг эрмэлздэг. Тухайлбал, 2023 онд хөгжиж буй орнуудын хөрөнгө оруулалтын бодлогын арга хэмжээний 86 хувь нь хөрөнгө оруулагчдад илүү тааламжтай, хөгжингүй орнуудын арга хэмжээний 57 хувь нь хязгаарласан буюу таатай бус байжээ.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалаас шууд хамаарч байна. Манай дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 75 орчим хувийг хувийн хэвшил бүрдүүлдэг. Хөдөө аж ахуй, боловсруулах, барилга, худалдаа зэрэг салбаруудын үйлдвэрлэлийг хувийн хэвшил дангаар бүрдүүлж байна. ДНБ 2023 онд 70.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 16.6 (30.8 хувь) их наяд төгрөгөөр өссөн. ДНБ-ний цэвэр өсөлт 7.4 хувь байсны 4.7 нэгж хувь нь

үйлчилгээний, 2.6 нэгж хувь нь уул уурхай, олборлолтын, 0.1 нэгж хувь нь бусад салбарт ногдож байна.

Монгол Улсад 1990-2023 онуудад нийт 44.1 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орсны 73.3 хувь нь уул уурхайн олборлолт, 10.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 3.9 хувь нь санхүүгийн үйлчилгээ, 2.2 хувь нь барилгын, 2.8 хувь нь бусад салбарт байна. ГШХО-ын дийлэнх нь зөвхөн нэг салбарт төвлөрөөд байна. 2011 оноос ганц Оюутолгой төслийн хөрөнгө оруулалт жил бүрийн ГШХО-ын тал хувийг бүрдүүлж ирлээ.

2023 онд манай улсын ГШХО-ын орох урсгал 3.5 тэрбум ам.доллар, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлт зэрэг гарах урсгал 1.2 тэрбум ам.доллар болжээ. Урсгалын цэвэр дүн 2.3 тэрбум ам.доллар орох урсгал байж, энэ нь өмнөх оноос 115 сая ам.доллаароор өссөн байна. Орох урсгалыг задалж харвал, мэргэжлийн шинжлэх ухааны салбарт 185 сая ам.доллаароор, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 97 сая ам.доллаароор өссөн бол, уул уурхайн олборлолтын хөрөнгө оруулалт 60 сая ам.доллаароор, барилгын хөрөнгө оруулалт 44 сая ам.доллаароор тус тус буурсан байна.

Сүүлийн 3 жилд Монгол Улсын аж ахуйн нэгжүүд 30.1 их наяд төгрөгийн татвар төлсний 8.8 их наяд төгрөгийг нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд төлжээ. Монгол Улсад одоогоор 246,944 аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс 9,013 нь гадаадын хөрөнгө оруулалттай компани байна. Мөн гурван жилд гадаадын хөрөнгө оруулалттай 992 компани татан буугдаж бүртгэлээс хасагджээ.

Аж ахуйн нэгжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрээр ялгаварласан, тодорхой үйл ажиллагаа явуулахыг хязгаарласан, хориглосон зохицуулалтаас шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хараат болон охин компани, компанийн нэгдлийг байгуулж буй нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодит хэмжээ, үр өгөөжийг тогтоох, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлоход хүндрэлтэй байна.

Монгол Улс гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татдаг ч, сонирхлыг бодит хөрөнгө оруулалт болгож чаддаггүй. Иймд хууль тогтоомжийг ил тод боловсруулж, урьдчилан таамаглахуйц тогтвортой бизнесийн орчныг бүрдүүлэхгүй бол хөрөнгө оруулагчид зах зээлээ хэтэрхий эрсдэлтэйд тооцож, илүү таатай орчин, өрсөлдөх чадвар бүхий улс орнуудыг сонгож байна.

Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, шинэ хөрөнгө оруулалтыг бүртгэх, виз болон оршин суух зөвшөөрлийг хөнгөвчлөх, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааг хялбаршуулж, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаа явуулах тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, мөн хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол, хүсэлтээ шийдвэрлүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлага үүссэн.

Гадаадын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул хөрөнгө оруулалтын бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн Газар бизнесийн таатай орчныг бүрдүүлэн гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын хэмжээ, үр өгөөжийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, гадаадын хөрөнгө оруулагчдад дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий “Хөрөнгө оруулалт, худалдааны газар” нэртэй агентлаг байгуулан гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг ажиллуулж, Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хууль эрх зүйн мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчийн гомдлыг хүлээн авах, шийдвэрлүүлэх зэрэг төрийн үйлчилгээг нэг дороос нэгдсэн байдлаар үзүүлж байна. Цаашид тус агентлагаар дамжуулж хөрөнгө оруулагчид тусгай зөвшөөрөл авах, маргаанаа шийдвэрлүүлэх, төртэй харилцах суваг болгох шаардлагатай. Мөн гадаадад суугаа Монголын элчин сайдын яамдад тус агентлагаас ажилтан томилж хөрөнгө оруулалт татах ажлыг бүтэн цагаар хийснээр давуу тал үүсч, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж буй бас нэг томоохон хүчин зүйл нь төрийн шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой үйл явц юм. Хуулийг хэрэгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх талаар нэгдсэн мэдээлэл эрх ашиг нь хөндөгдөх этгээдэд хүргэх ажил хангалттай биш учраас хөрөнгө оруулагчид асар их зардал чирэгдэл учирч байна. Хөрөнгө оруулагчийн мэдэх эрхийг хангах, саналаа өгөх боломжийг бүрдүүлдэг байх нь чухал юм.

Түүнчлэн хөрөнгө оруулагчийн хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх нэгдсэн зарчмыг тодорхойлоогүйгээс төрийн байгууллага, албан тушаалтнаас хуулийг өөрийн үзэмжээр тайлбарлах, дур зоргоор шийдэх эрсдэлийг бий болгож байна. Иймд хөрөнгө хураан авахад олгох нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох нөхцөлийг хуульчлах нь зүйтэй байна.

Улмаар төрийн байгууллага, албан хаагчийн хууль бус үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсэн хөрөнгө оруулагчийн гомдол, маргааныг нэн тэргүүнд эвийн журмаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна. Хөрөнгө оруулагчийн эрхийг зөрчсөн гомдол маргааны шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг бүртгэдэг, олон нийтэд нээлттэй байх, хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэхгүй удааширсан бол Засгийн газрын түвшинд асуудлыг сонсож, чиглүүлэх шийдлийг бий болгох, албан тушаалтны үүрэг, хариуцлагыг сайжруулах шаардлага бий болоод байна.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаагаа шуурхай явуулах нөхцөлөөр хангах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргааныг шийдвэрлүүлэх тогтолцоо нь шуурхай, оновчтой биш байгаа нь хөрөнгө оруулагчдын Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхол, итгэл үнэмшлийг бууруулж байна.

Хуулийн засаглал бүрэн хэрэгждэггүй, шүүхээр гадаадын хөрөнгө оруулагчдын хэргүүдийг шийдвэрлэхгүйгээр, олон сар, жилээр гацаадаг болоод байна. Засгийн газрын шийдвэрүүд орон нутгийн түвшинд хэрэгждэггүй тул орон нутгийн иргэд, удирдлагууд гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн төслүүдийг хүчээр, эсвэл эс үйлдлээрээ зогсоодог, үүний улмаас хөрөнгө оруулагчид цаг хугацаа, боломжоо алдаж, санхүүгийн ихээхэн хохирол амссаар байна. Мөн гадаадын хөрөнгө оруулагчид гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулахдаа төлдөг ажлын байрны төлбөрийг бууруулах болон цуцлах хүсэлтүүдийг тавьдаг.

Олон улсын жишгээс харахад хөгжиж байгаа улсуудын ихэнх нь ГШХО-ын тухай хуультай байна. Тухайлбал, НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD)-ын улс орнуудын хөрөнгө оруулалтын хуулиудыг харьцуулсан судалгаагаар хамгийн багадаа 108 улс хөрөнгө оруулалтын хуультай болохыг тогтоожээ. Эдгээр хуулиудын 58 хувь (64) нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг, бусад нь зөвхөн гадаадын хөрөнгө оруулалтыг тусгайлсан хууль байна. Ялангуяа Азийн орнууд гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай байдаг бол Африкийн ихэнх улс орнууд хөрөнгө оруулалтын ерөнхий хуулийг баталсан байдаг.<sup>1</sup>

Манай улсын хувьд хөрөнгө оруулалтын харилцааг анх 1993 онд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулж байсныг 2013 оноос Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулах болсон. Хөрөнгө оруулалтын тухай хууль хэрэгжсэн өнөөдрийг хүртэлх 11 жилийн хугацаанд Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт 15 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсны дийлэнх нь бусад хуулийг дагалдаж нэмэлт, өөрчлөлт орсон байгаа ба энэ нь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах асуудалд чиглээгүй байна.

Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын сүүлийн 10 жилийн статистик тоон мэдээнээс харахад 2013 онд хууль батлагдсанаас хойш хөрөнгө оруулалтын хэмжээ тасралтгүй буурсан ч 2017-2019 оны хооронд оюу толгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалт, дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн ч дэлхий дахинаа тархсан ковид 19 цар тахлын нөлөөгөөр хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан байна. Энэхүү үзүүлэлтээс дүгнэхэд, манай улсын хууль тогтоомж нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах хангалттай нөхцөл бүрдээгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон, бүтэц, зүйл, заалтын 50-иас дээш хувьд нь өөрчлөлт орохоор байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төслийн нэрийг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль гэж өөрчлөн боловсруулах ба дараах зарчмыг тусгана. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин тогтвортой байх;
- Хууль дээдлэх зарчмыг тусган, хуулийг нэг мөр, хэлбэрэлтгүй хэрэгжүүлдэг байх;
- Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг дордуулахаар бол хуулийг буцаан хэрэглэхгүй байх;
- Гэрээний үүрэг чанд биелэгдэх;
- нээлттэй, ил тод байх зэрэг үндсэн зарчмуудыг хуулийн төсөлд тусгана.

Түүнчлэн, хуулийн төсөлд төрийн болон компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх, төр болон хөрөнгө оруулагчийн эрх, үүргийн тэнцвэртэй байдлыг

---

<sup>1</sup> [https://unctad.org/system/files/official-document/webdiaepcb2016d5\\_en.pdf](https://unctad.org/system/files/official-document/webdiaepcb2016d5_en.pdf)

хангах, хөрөнгө оруулагчийг дэмжих, урамшуулах, эрх ашгийг хамгаалах эрх зүйн тогтолцооны талаарх олон улсын байгууллагуудын зөвлөмж, сайн туршлагыг тусгана.

## **Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль гэж өөрчилнө.

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг гадаадын шууд хөрөнгө оруулалтад түшиглэн дэмжих, Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын баталгааг тогтоох, гадаадын хөрөнгө оруулагчид татварын болон татварын бус урамшуулал үзүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох, хөрөнгө оруулалтыг хадгалах, дэмжих талаар төрийн байгууллагуудын эрх, үүргийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах юм.

Хуулийн төсөл нь 7 бүлэг, 35 зүйлтэй байх ба хөрөнгө оруулагчийн хууль ёсны баталгааг хангах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг дэмжих, тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх дараах зохицуулалтыг шинээр тусгана:

1.Хуулийн үйлчлэх хүрээг Монгол Улсад гадаадаас орж буй хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, хөрөнгө оруулалтын баталгааг тогтоох, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцаанд хамаарахаар зааж, хуулийг “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль” гэж нэрлэнэ.

2.Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг оновчтой, ойлгомжтой болгож, хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт шаардсан хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтны эрх хэмжээг тодорхойлж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломж бүрдүүлнэ.

3.Энэ хуулийн хүрээнд зохицуулах харилцаанд дараах нийтлэг зарчмыг баримтална:

- Тогтвортой байх: Төрийн бодлого, хууль тогтоомж тогтвортой мөрдөгддөг байх, аливаа бодлогын өөрчлөлт нь урьдчилан таамаглахуйц байх;

- Шударга, тэгш байх: Хуулийг буцаан хэрэглэхгүй байх, гэрээний үүргээ үл маргах журмаар, ёсчлон биелүүлдэг байх;

- Ойлгомжтой байх: Хууль тогтоомж нь нийтэд ил тод бөгөөд, тодорхой, ойлгомжтой буюу хоёрдмол утга санаагүй байх, нэг эх үүсвэрээс олгож, хөрөнгө оруулагчдын цаг хугацаа, зардлыг хэмнэдэг байх;

- Шуурхай байх: Төрийн байгууллагуудын уялдааг сайжруулж, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гомдол шийдвэрлэх бүтцийг бий болох;

- Цахим байх: Дээрх зарчмуудыг хэрэгжүүлэх цахим шийдэл нэвтрүүлсэн байх;

4. Хуулийн төсөлд шинээр гадаадын хөрөнгө оруулалтын талаарх Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төрийн бусад

байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, дипломат төлөөлөгчийн газрын эрх, үүргийг шинээр тусгаж, төрийн байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл байдал, уялдааг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

5. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнээр ахлуулсан гадаадын хөрөнгө оруулалтын зөвлөл байгуулах болон зөвлөлийн эрх, үүргийн асуудлыг энэхүү хуулиар тодорхойлно. Энэ зөвлөл нь гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлж, зөвлөмжүүдийг боловсруулна. Түүнчлэн, гадаадын хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл гомдол хүлээн авч, эвлэрүүлэн зуучлах, хялбаршуулсан горимоор шийдвэрлэх зохицуулалт оруулж, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлнэ.

6. Хуулийн төсөлд Монгол Улсын хөгжлийн бодлогод тодорхойлогдсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудад оруулах гадаадын хөрөнгө оруулалтад олгох нэн таатай болон таатай нөхцөл, шууд болон шууд бус урамшууллыг тодорхойлж, хөрөнгө оруулалтаа хийж буй эсэхэд хяналт тавих зохицуулалтыг тусгана. Засгийн газар эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийг 4 жил тутмын үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгаж, эдгээр салбарт явуулах урамшууллын бодлогыг тодорхойлж, УИХ-аар хэлэлцүүлэх талаар тусгана.

7. Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулахаар сонирхож буй аж ахуйн нэгжүүдэд зориулсан хууль, эрх зүйн болон хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулагчдад туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчлан тусгаж, хөрөнгө оруулагчдад зөвлөх, дэмжих, бизнесийн орчны мэдээлэл хүргэх зэрэг үйлчилгээг нэг цонхоор, цахимаар үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

**Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгэм, хууль зүйн хувьд дараах үр дүн гарна. Үүнд:

Гадаадын хөрөнгө оруулалтын илүү таатай орчин бүрдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой, зохимжтой өсөлтийг хангах нөхцөл бүрдэнэ.

Эдийн засгийг төрөлжүүлж, үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад худалдааг өргөжүүлэх, дэвшилтэд техник технологи, ноу-хау нэвтэрснээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжирч, инновацыг дэмжих замаар Монгол Улсын өрсөлдөх чадвар дээшилнэ.

Тогтвортой ажлын байр бий болж, шинэ мэдлэг, ур чадварыг эзэмшүүлж, ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, дундаж цалингийн хэмжээ болон өрхийн орлого нэмэгдэнэ.

Хөрөнгө оруулалтад тулгуурлан дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалт нэмэгдэж, тээвэр, логистикийн зардал буурах, ханган нийлүүлэлтийн сүлжээний үр ашиг нэмэгдэх, улмаар шинээр хөрөнгө оруулалт татах боломжийг бүрдүүлнэ.

Хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр татварын бааз суурь тэлж, төсвийн орлого нэмэгдэн улс болон орон нутгийн хөгжлийг хурдасгаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Хөрөнгө оруулагчдын маргааныг шударгаар, шуурхай шийдвэрлэдэг механизмыг бүрдүүлнэ.

Үндэсний хөрөнгө оруулагчдын эрх зүйн нөхцөл байдлыг дордуулахгүйгээр, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хэлэлцээр болон бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын Ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль болон "Хуулийн хэрэгжилт хангуулах тухай" Улсын Их хурлын тогтоолын төсөл зэргийг тус тус боловсруулна.